



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Мал эмнэлгийн газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/131/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот	2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: <a href="mailto:gunjidmaag@audit.gov.mn">gunjidmaag@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a> Ахлах аудитор: М.Атарцэцэг Утас: 88984411 Цахим хаяг: <a href="mailto:atarsetsegm@audit.gov.mn">atarsetsegm@audit.gov.mn</a> Аудитор: Б.Мөнхболд Утас: 99041008 Цахим хаяг: <a href="mailto:munkhboldbo@audit.gov.mn">munkhboldbo@audit.gov.mn</a>
--	---------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099  
Утас: (976) 70 48 34 13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 02. 21 № 63

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Мал эмнэлгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд 388,113.5 мянган төгрөгийн вакциныг мал, амьтанд тарьж, үйлчилгээний хөлс 450,954.1 мянган төгрөгийг олгосон байна. Нийт 42,477.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч, 29,582.2 мянган төгрөгийн 1 суудлын машин, 3 принтерийг шилжүүлэн авсан байна. Албан контор, лаборатор болон автомашинд нийт 31,025.3 мянган төгрөгийн урсгал засвар хийсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Нэмэлт санхүүжилтээс цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 30,755.5 мянган төгрөгийг, тээвэр, шатахуун, эм,

8225020158

бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэлд 138,680.9 мянган төгрөгийг, хөдөлмөр хамгааллын хэрэглэл, албан томилолтод 41,910.9 мянган төгрөгийг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 548,171.7 мянган төгрөгийг, нийт 759,519.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### **Бусад асуудал**

Тайлант онд 8 зорилт, 36 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 33 арга хэмжээг 100.0 хувь, 2 арга хэмжээг 90.0 хувь, 1 арга хэмжээг 70.0 хувь буюу нийт дүнгээр 98.6 хувиар биелэснээр тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ГҮНЖИДМАА



## Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>177,433,452.96</u></b>	<b><u>205,302,998.02</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	4,225,896.00	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	4,225,896.00	-
3351	Байгууллагаас авах авлага	3,134,592.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,091,304.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	173,207,556.96	205,302,998.02
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	131,214,169.13	159,999,986.86
35110	Тусгай зориулалттай материал	31,739,343.00	31,739,343.00
35130	Эм боох материал	99,474,826.13	128,260,643.86
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	41,993,387.83	45,303,011.16
35410	Бичиг хэргийн материал	1,187,306.00	1,132,056.00
35420	Аж ахуйн материал	29,007,504.00	28,981,004.00
35440	Түлш, шатах тослох материал	-	3,044,140.00
35470	Бусад хангамжийн материал	11,798,577.83	12,145,811.16
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>594,367,999.12</u></b>	<b><u>511,590,764.20</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	594,367,999.12	511,590,764.20
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	534,971,332.38	452,194,097.46
39201	Барилга, байгууламж, орон сууц	66,524,023.03	84,524,023.03
39202	Хуримтлагдсан элэгдэл	(10,099,765.39)	(13,730,360.23)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	242,762,257.15	263,762,257.15
39204	Хуримтлагдсан элэгдэл	(160,389,103.46)	(205,075,832.25)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	634,700,467.28	667,759,667.28
39206	Хуримтлагдсан элэгдэл	(266,054,895.66)	(368,237,768.35)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,963,205.00	37,963,205.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,434,855.57)	(14,771,094.17)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	59,396,666.74	59,396,666.74
39301	Програм хангамж	1,980,000.00	1,980,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(403,333.26)	(403,333.26)
39303	Бусад биет бус хөрөнгө	57,820,000.00	57,820,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>771,801,452.08</u></b>	<b><u>716,893,762.22</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>3,134,592.00</u></b>	<b>-</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	3,134,592.00	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	3,134,592.00	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	3,134,592.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	3,134,592.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>768,666,860.08</u></b>	<b><u>716,893,762.22</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	768,666,860.08	716,893,762.22
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	712,399,718.43	660,626,620.57
51210	Өмнөх үеийн үр дүн	712,399,718.43	712,399,718.43
51220	Тайлант үеийн үр дүн	-	(51,773,097.86)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	56,267,141.65	56,267,141.65
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>771,801,452.08</u></b>	<b><u>716,893,762.22</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,331,892,297.87</b>	<b>2,726,960,414.87</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>393,126,965.87</b>	<b>254,227,264.87</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>393,126,965.87</b>	<b>254,227,264.87</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,500,200.00	254,227,264.87
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500,200.00	1,631,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	129,733,191.92	-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	261,893,573.95	252,596,264.87
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,938,765,332.00</b>	<b>2,472,733,150.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,217,461,000.00</b>	<b>1,716,348,700.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,217,461,000.00	1,716,348,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>721,304,332.00</b>	<b>756,384,450.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	544,000,000.00	570,255,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	177,304,332.00	186,128,950.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,272,748,215.14</b>	<b>2,773,206,540.73</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,272,748,215.14</b>	<b>2,773,206,540.73</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,058,465,105.70</b>	<b>2,552,554,146.54</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>796,377,461.57</b>	<b>1,160,299,456.75</b>
210101	Үндсэн цалин	564,491,565.00	656,145,029.70
210102	Нэмэгдэл	172,185,673.00	358,313,947.96
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,303,242.57	87,952,479.09
210104	Урамшуулал	31,396,981.00	57,888,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>108,498,816.06</b>	<b>153,436,460.64</b>
210201	Тэтгэврийн даатгал	74,006,843.06	99,938,379.21
210202	Тэтгэмжийн даатгал	8,154,557.00	12,171,911.63
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,272,300.00	14,243,482.46
210204	Ажилгүйдлийн даатгал	1,527,996.00	5,375,916.79
210205	Эрүүл мэндийн даатгал	16,537,120.00	21,706,770.55
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>29,263,178.99</b>	<b>35,418,468.42</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,717,077.60	3,689,725.39
210302	Түлш, халаалт	25,210,381.39	30,953,793.03
210303	Цэвэр, бохир ус	335,720.00	774,950.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>33,197,300.90</b>	<b>36,427,651.00</b>
210401	Бичиг хэрэг	3,770,600.00	3,532,900.00
210402	Тээвэр, шатахуун	21,756,791.00	26,586,860.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,144,209.90	2,819,116.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,285,700.00	3,248,775.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>414,489,531.43</b>	<b>465,016,916.81</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	414,405,031.43	465,016,916.81
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	84,500.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>15,487,700.00</b>	<b>33,156,170.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	250,000.00	3,690,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	16,440,900.00
210604	Урсгал засвар	15,237,700.00	13,025,270.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>16,690,000.00</b>	<b>52,932,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	16,690,000.00	52,932,000.00



<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>507,339,642.04</b>	<b>461,030,588.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,334,710.00	450,319,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	840,400.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	377,040.00	409,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	286,392.04	198,988.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	132,000.00	154,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,080,000.00	9,660,000.00
210807	Газрын төлбөр	289,100.00	289,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>137,121,474.71</b>	<b>154,836,434.92</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,405,360.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	123,940,437.71	154,836,434.92
210904	Найдваргүй авлагын алдагдал	8,775,677.00	
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>214,283,109.44</b>	<b>220,652,394.19</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>63,080,600.00</b>	<b>136,526,970.10</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	63,080,600.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	136,006,970.10
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	520,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>79,604,130.77</b>	<b>84,125,424.09</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	79,497,787.87	84,125,424.09
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	106,342.90	
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(39,354,400.35)</b>	<b>(46,246,125.86)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>5,526,972.00</b>
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал /Үндсэн хөрөнгө/	-	-
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал /Бараа материал/	-	5,526,972.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-</b>	<b>(5,526,972.00)</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(39,354,400.35)</b>	<b>(51,773,097.86)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,940,265,532.0</b>	<b>2,477,498,742.0</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,500,200.0</b>	<b>1,631,000.0</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,500,200.0</b>	<b>1,631,000.0</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,500,200.0	1,631,000.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500,200.0	1,631,000.0
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,938,765,332.0</b>	<b>2,475,867,742.0</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,217,461,000.0</b>	<b>1,716,348,700.0</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,217,461,000.0	1,716,348,700.0
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>721,304,332.0</b>	<b>759,519,042.0</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	544,000,000.0	570,255,500.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	177,304,332.0	189,263,542.0
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,935,265,532.0</b>	<b>2,478,590,046.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,935,265,532.0</b>	<b>2,478,590,046.0</b>



<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,720,982,422.6</b>	<b>2,257,937,651.8</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>796,377,461.6</b>	<b>1,160,299,456.8</b>
210101	Үндсэн цалин	564,491,565.0	656,145,029.7
210102	Нэмэгдэл	172,185,673.0	358,313,948.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,303,242.6	87,952,479.1
210104	Урамшуулал	31,396,981.0	57,888,000.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>108,498,816.1</b>	<b>153,436,460.6</b>
210201	Тэтгэврийн даатгал	74,006,843.1	99,938,379.2
210202	Тэтгэмжийн даатгал	8,154,557.0	12,171,911.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,272,300.0	14,243,482.5
210204	Ажилгүйдлийн даатгал	1,527,996.0	5,375,916.8
210205	Эрүүл мэндийн даатгал	16,537,120.0	21,706,770.6
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>29,263,179.0</b>	<b>35,418,468.4</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,717,077.6	3,689,725.4
210302	Түлш, халаалт	25,210,381.4	30,953,793.0
210303	Цэвэр, бохир ус	335,720.0	774,950.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>31,980,323.9</b>	<b>37,820,466.0</b>
210401	Бичиг хэрэг	3,646,150.0	3,477,650.0
210402	Тээвэр, шатахуун	19,628,864.0	28,771,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,144,209.9	2,819,116.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.0	240,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,321,100.0	2,512,700.0
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>214,063,240.0</b>	<b>144,380,788.0</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	212,683,540.0	144,380,788.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,379,700.0	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>16,734,900.0</b>	<b>75,888,170.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,335,000.0	28,422,000.0
		-	16,440,900.0
210604	Урсгал засвар	15,399,900.0	31,025,270.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>16,690,000.0</b>	<b>52,932,000.0</b>
210702	Дотоод албан томилолт	16,690,000.0	52,932,000.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>507,339,642.0</b>	<b>597,761,842.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,334,710.0	587,050,754.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	840,400.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	377,040.0	409,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	286,392.0	198,988.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	132,000.0	154,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,080,000.0	9,660,000.0
210807	Газрын төлбөр	289,100.0	289,100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>34,860.0</b>	<b>-</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,860.0	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>214,283,109.4</b>	<b>220,652,394.2</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>63,080,600.0</b>	<b>136,526,970.1</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	63,080,600.0	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	136,006,970.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	520,000.0
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>5,000,000.0</b>	<b>(1,091,304.0)</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>5,000,000.0</b>	<b>42,477,000.0</b>

22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>5,000,000.0</b>	<b>42,477,000.0</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>5,000,000.0</b>	<b>42,477,000.0</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,000,000.0	42,477,000.0
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(5,000,000.0)</b>	<b>(42,477,000.0)</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	(43,568,304.0)
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	(43,568,304.0)

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	56,267,141.7	645,155,635.7	701,422,777.4
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	8,100,000.0	8,100,000.0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	56,267,141.7	653,255,635.7	709,522,777.4
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	59,144,082.7	59,144,082.7
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	56,267,141.7	712,399,718.4	768,666,860.1
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	56,267,141.7	712,399,718.4	768,666,860.1
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	56,267,141.7	712,399,718.4	768,666,860.1
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(51,773,097.9)	(51,773,097.9)
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	56,267,141.7	660,626,620.6	716,893,762.2

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,580,489,200.0	1,719,071,004.0	138,581,804.0	108.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,580,489,200.0	1,719,071,004.0	138,581,804.0	108.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,579,961,200.0	1,498,418,609.8	(81,542,590.2)	94.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,199,357,800.0	1,131,612,156.8	(67,745,643.2)	94.4
210101	Үндсэн цалин	678,412,400.0	654,714,029.7	(23,698,370.3)	96.5

210102	Нэмэгдэл	352,124,300.0	331,057,648.0	(21,066,652.0)	94
210103	Унаа хоолны хөнгөлөлт	80,015,800.0	87,952,479.1	7,936,679.1	109.9
210104	Урамшуулал	88,805,300.0	57,888,000.0	(30,917,300.0)	65.2
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>161,339,900.0</b>	<b>151,368,260.6</b>	<b>(9,971,639.4)</b>	<b>93.8</b>
210201	Тэтгэврийн даатгал	102,337,100.0	97,870,179.2	(4,466,920.8)	95.6
210202	Тэтгэмжийн даатгал	12,739,400.0	12,171,911.6	(567,488.4)	95.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,414,800.0	14,243,482.5	(171,317.5)	98.8
210204	Ажилгүйдлийн даатгал	6,369,800.0	5,375,916.8	(993,883.2)	84.4
210205	Эрүүл мэндийн даатгал	25,478,800.0	21,706,770.6	(3,772,029.4)	85.2
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>36,622,800.0</b>	<b>35,418,468.4</b>	<b>(1,204,331.6)</b>	<b>96.7</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,114,800.0	3,689,725.4	(425,074.6)	89.7
210302	Түлш, халаалт	31,727,100.0	30,953,793.0	(773,307.0)	97.6
210303	Цэвэр, бохир ус	780,900.0	774,950.0	(5,950.0)	99.2
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>27,293,100.0</b>	<b>26,917,866.0</b>	<b>(375,234.0)</b>	<b>98.6</b>
210401	Бичиг хэрэг	3,574,700.0	3,477,650.0	(97,050.0)	97.3
210402	Тээвэр, шатахуун	17,869,400.0	17,868,400.0	(1,000.0)	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,096,300.0	2,819,116.0	(277,184.0)	91
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.0	240,000.0	-	100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,512,700.0	2,512,700.0	-	100
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>16,689,500.0</b>	<b>16,602,500.0</b>	<b>(87,000.0)</b>	<b>99.5</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,689,500.0	16,602,500.0	(87,000.0)	99.5
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>59,665,900.0</b>	<b>59,447,270.0</b>	<b>(218,630.0)</b>	<b>99.6</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	28,640,000.0	28,422,000.0	(218,000.0)	99.2
210604	Урсгал засвар	31,025,900.0	31,025,270.0	(630.0)	100
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>27,604,800.0</b>	<b>27,462,000.0</b>	<b>(142,800.0)</b>	<b>99.5</b>
210702	Дотоод албан томилолт	27,604,800.0	27,462,000.0	(142,800.0)	99.5
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>51,222,900.0</b>	<b>49,590,088.0</b>	<b>(1,632,812.0)</b>	<b>96.8</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,879,000.0	38,879,000.0	-	100
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	824,400.0	-	-	-
210803	Даатгалын үйлчилгээ	409,000.0	409,000.0	-	100

210804	Тээврийн хэрэгслийн татвар	402,200.0	198,988.0	(203,212.0)	49.5
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	162,300.0	154,000.0	(8,300.0)	94.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,256,900.0	9,660,000.0	(596,900.0)	94.2
210807	Газрын төлбөр	289,100.0	289,100.0	-	100
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	164,500.0	-	-	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	164,500.0	-	-	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	528,000.0	220,652,394.2	<b>220,124,394.2</b>	<b>#####</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	528,000.0	136,526,970.1	135,998,970.1	<b>#####</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	136,006,970.1	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	528,000.0	520,000.0	(8,000.0)	98.5
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>1,717,979,700.0</b>	-	-
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	<b>1,716,348,700.0</b>	-	-
310001	Улсын төсвөөс санхүүжих	-	1,716,348,700.0	-	-
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	1,631,000.0	-	-
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,631,000.0	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	54	54	0	100
620001	удирдах ажилтан	1	1	0	100
620002	гүйцэтгэх ажилтан	53	41	(12.00)	100


## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>759,519,042.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	759,519,042.0
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	759,519,042.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	28,687,300.00
210101	Үндсэн цалин	-	1,431,000.00
210102	Нэмэгдэл	-	27,256,300.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	-	2,068,200.00
210201	Тэтгэврийн даатгал	-	2,068,200.00



<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	10,902,600.00
210402	Тээвэр, шатахуун	-	10,902,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	127,778,288.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	127,778,288.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	16,440,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	16,440,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	25,470,000.00
210702	Дотоод албан томилолт	-	25,470,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	548,171,754.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	548,171,754.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>759,519,042.0</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	759,519,042.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	570,255,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	189,263,542.00



## Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар 350,918.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Санхүүгийн үр дүнгийн тайланд Нормативт зардлыг 349,321.9 мянган төгрөгөөр, Хангамж, бараа материалын зардлыг 1,596.1 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.
- Мөнгөн гүйлгээний тайланд тээвэр шатахууны зардлыг 384.4 мянган төгрөгийн зардлыг зөрүүтэй тайлагнасан нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 5,745.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 5,745.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

### 3.2 Төлбөрийн акт

1. Ажилтны амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулан 310.7 мянган төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан илүү олгосон амралтын цалин 310.7 мянган төгрөгийг төлүүлж орон нутгийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

### 3.3 Албан шаардлага

1. Жилийн эцсийн тооллогоор 12,182.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 50,487.6 мянган төгрөгийн бараа материалыг нягтлан бодох бүртгэлийн дүнгээс зөрүүтэй буюу дутуу тоолж баримтжуулсан, нягтлан бодогч тооцоо бодоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж,

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэнтэй нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үдсэн хөрөнгийн тооллогыг үнэн зөв хийж, тооцоог бодох албан шаардлага хүргүүлсэн.

### **3.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Бараа материалтай холбоотой асуудал**


##### Илрүүлэлт:

Түүвэрчилсэн тооллого хийхэд агуулахад малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, болзошгүй онцгой үед хэрэглэх нөөцөлсөн оношлогоо, шинжилгээний материалууд нягтлан бодох бүртгэл дэх дүнгээс 5,434.3 мянган төгрөгийн зөрүүтэй, агуулахад байгаа бараа материал эмх цэгц, замбараагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна". 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна", 68 дугаар зүйлийн 68.1-т "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг бүртгэн авч хадгалах, түүнийг нэр төрөл, чанар, бүрдлийн хувьд бүрэн бүтэн байлгах, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тавьж олгох, үүрэг бүхий этгээдийг эд хариуцагч гэнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зөвлөмжийн дагуу хийх ажлын төлөвлөгөө гарган батлуулж, үндсэн хөрөнгө, бараа материалыг бүрэн үнэн зөв тоолж, тооцоог бодож, агуулахыг эмх цэгцтэй болгох

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



**Дөрөв. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:**

/мянган төгрөгөөр/

**4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Говь-Алтай аймгийн Мал эмнэлгийн газар	Санхүүгийн үр дүнгийн тайланд Нормативт зардлыг 349,321.9 мянган төгрөгөөр, Хангамж, бараа материалын зардлыг 1,596.1 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан.	1	350,918.0	-	-	1	350,918.0	1	350,918.0	-	-	-	-
	<b>Дүн</b>	1	350,918.0	-	-	1	350,918.0	1	350,918.0	-	-	-	-

**4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12		
Говь-Алтай аймгийн Мал эмнэлгийн газар	Жилийн эцсийн тооллогоор 12,182.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 50,487.6 мянган төгрөгийн бараа материалыг нягтлан бодох бүртгэлийн дүнгээс зөрүүтэй буюу дууу тоолж баримтжуулсан, нягтлан бодогч тооцоо бодоогүй. Түүвэрчилсэн тооллого хийхэд агуулахад малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, болзошгүй онцгой үед хэрэглэх нөөцөлсөн оношлогоо, шинжилгээний материалууд нягтлан	1	5,434.3	-	-	1	-	-	-	-	-	-	-
		1	5,434.3	-	-	-	-	1	5,434.3	-	-	-	-

	<p>бодох бүртгэл дэх дүнгээс 5,434.3 мянган төгрөгийн зөрүүтэй, агуулахад байгаа бараа материал эмх цэгц, замбараагүй байна.</p> <p>Ажилтны амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулан 310.7 мянган төгрөгийг илүү олгосон.</p>																			
	<b>3</b>	<b>5,745.0</b>	<b>1</b>	<b>310.7</b>	<b>1</b>	<b>310.7</b>	<b>1</b>	<b>724.0</b>	<b>1</b>	<b>5,434.3</b>										
	<b>ДҮН</b>																			

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо										Санал дүгнэлтийн хэлбэр										
		Аудитад хамрагдах					Үүнээс: Аудит хийсэн хэлбэр					Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан							
		1	2	3	4	5	Санал дүгнэлт гаргасан	Түвшрт хамруулсан	Аудит хийгээгүй													
А	1																					
1	ТШЗ			1																		
	<b>НИЙТ</b>			<b>1</b>																		

